

**ЭРХ МЭДЭЛ ХУВААРИЛАХ ОНОЛ, ХОЁР ТАНХИМТАЙ СОНГОДОГ
ПАРЛАМЕНТ НЬ АРДЧИЛСАН ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ҮНДЭС МӨН**

Г.ЦЭНД-АЮУШ

Доктор, дэд проф, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,

Улс төр судлалын тэнхим

Д.СҮХБОЛД

Докторант

*“Эрх мэдлийг хуваарилж тэнцвэржүүлээгүй
улс оронд үндсэн хууль оршдоггүй”
(1789 оны Парижийн тунхагаас)*

Түлхүүр үг: Эрх мэдэл хуваарилах онол, хоёр танхимтай сонгодог парламент ардчилсан төрийн тогтолцооны үндэс суурь болох нь. Эрх мэдэл хуваарилах үзэл санаа их сэтгэгчдийн хүч чармайлтаар боловсрогдсон болно.

Төрийн засаглал яагаад деспот хэлбэрт шилждэг болох, засаглалыг дарангуйлалын хэлбэрт оруулахгүй байх гол баталгаа нь ард түмэн өөрсдөө. Монголын төрт ёсонд хоёр танхим бүхий хурал байсан.

Краткий обзор: В данной статье отражена теория разделения власти, разработанная мыслителями разных эпох. Указана необходимость реализации принципа разделения власти в классической модели в нынешней монгольской политической практике исходя из политической традиции двухпалатного парламента, существовавшего со времени Богдо-Хантской Монголии.

Хүмүүн төрөлхтөн үүсэж төр нийгмийн байгуулалд шилжсэн цагаас хойш төгс төгөлдөр төрийн тухай, хамгийн сайн засаглал, хамгийн сайн удирдлага, хамгийн төгс нийгмийн байгууллыг эрж хайсаар ирсэн. Энэ зорилгодоо хүрэх үүднээс

Грекийн их сэтгэгч Платон, Аристотель, Хятадын Күнз, Ромын Цицерон, Италийн Макиавелли, Францын Руссо, Монтескье, Английн Гоббс, Локк, Голландын Гроций, Спиноза гээд хүн төрөлхтний сор болсон нэртэй их сэтгэгчид, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, сонгууль, эрх зүйт болон социал төр, иргэний нийгмийн байгуулал, үндсэн хуульт ёс, эрх мэдэл хуваарилах онол, ард түмний төлөөлөл болсон парламент зэрэг ардчилсан тогтолцооны үнэт зүйлүүдийн гол төсөөллийг гаргаж ирсэн билээ. Аливаа хувьсгал шинэчлэл радикал үйл ажиллагаанууд ч эцсийн дүндээ дээрх үнэт зүйлсийг бий болгохын төлөө хүмүүс жам ёсны эрх, эрх чөлөөгөө эдлэх, хамгаалахын тулд явагдаж ирсэн. 17-18-р зууны Английн хувьсгал, Голландын хувьсгал, Францын хөрөнгөтний хувьсгал, Монголчуудын 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал, 1990 оны ардчилсан хувьсгал дээрхийг гэрчилнэ. Хүний эрхийн төлөөх тэмцлийн түүх бол хүн төрөлхтний сайн сайхан амьдрах улс төр, эдийн засаг, нийгмийн орчныг бүрдүүлэхийн төлөөх тэмцлийн түүхийн нэгээхэн хэсэг мөн.

Бид энэхүү өгүүлэлийн хуудаснаа өнөөгийн ардчилсан төрийн тогтолцооны үндэс суурь болсон эрх мэдэл хуваарилах онол болон парламентаг ёсны талаар санал бодлоо хуваалцах зорилго тавьсан болно.

Энэ үйл явц хэрхэн явагдсан бэ?. Жишээ болгож 1789 оны Францын хөрөнгөтний хувьсгалыг эргэн харъя.

Хөрөнгөтний хувьсгалын өмнөх Франц орон хэмжээгүй эрхт хаант засаглал бүхий язгууртны харилцаа ноёрхсон орон байв. Эзэн хаанаар толгойлуулсан язгууртнууд улс орны үйлдвэрлэх гол салбар болсон хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын гуравны хоёрыг эзэмшин захирч, төрийн өндөр дээд албан тушаалуудыг монополичлон эзэмшиж, харин эсрэг талд газар тариалан, үйлдвэрийн салбарт ажиллагсад, ядуу тариачид, энгийн ард иргэд, үгээгүй ядуучууд амь зууж байлаа.

Францын эзэн хаан 14-р Людовик “төр бол би” гэж хэлээд сахал хусагч үсчний албан тушаал, түлээ бэлтгэлтэнд хяналт тавих ван эзний зөвлөх, давсалсан тос амтлагчийн албан тушаал зэрэг шинэ шинэ зохиомол албан тушаалуудыг бий болгож дамлан худалдаж байв. /Өнөөгийн Монгол биш гэж үү?. 1992-1996 онд 8 яамтайгаар ажиллаж байсан Монголын засгийн газар өдгөө 16 яам, 33 сайд, 20 тохируулагч, 30 хэрэгжүүлэгч агентлаг, 4200 төсвийн байгууллагатай болжээ. 2006 онд төрийн албан хаагчдын тоо

128 мянга байсан бол 2015 онд энэ тоо даруй 180 мянга гаруйд хүрчээ./

Энэ бүхнийг дэвшин хөгжиж буй капиталист харилцаанд суурилсан шинэ хөрөнгөтнүүд, улс төрийн сэтгэгч соён гэгээрүүлэгчид, ард түмэн тэвчээгүй юм.

Тэд нийгмийн дэвшлийн шинэ арга замыг хайж хэмжээгүй эрхт хаант засаглалын эсрэг үзэл санааг бүрэлдүүлж байлаа. Францын ирээдүйн хувьсгалын хөдөлгөгч хүч болсон шинэ хөрөнгөтнүүдийн үзэл баримтлал нь хувьсгалын өмнө ерөнхийдөө цэгцлэгдсэн байсан. Тэдний үзэл баримтлал бүрэлдэн тогтоход өмнөх үеийн сэтгэгчид болох Ш.Л.Монтескье, Ж.Руссо, Ф.Вольтер зэрэг соён гэгээрүүлэгчдийн үзэл санаа чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Эдгээр соён гэгээрүүлэгчдийн үзэл санаа нь тэр үеийн шинэ залуу хөрөнгөтнүүдийн хүсэл тэмүүлэлтэй ихэд тохирч байв.

Соён гэгээрүүлэгчид нийгмийн амьдралыг шинэлэг зөв зохистой зарчмаар нь, мөн хүмүүнлэг ёсны талаас нь хөгжүүлэхийг эрмэлзэж байлаа. Тэд цэвэр оюуны хүч чадлыг шүтэж ард иргэдийг харанхуй бүдүүлэг байдлаас ангижруулах, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг нийгэмд төлөвшүүлэх гэсэн үзэл санааг тууштай баримталж байв.

Нөгөөтэйгүүр Английн Ж.Локк, Т.Гоббс, Францын Ж.Руссо, Ш.Л.Монтескье зэрэг нэрт сэтгэгчдийн үзэл баримтлалын цөм нь тэр үеийн хэмжээгүй эрхт хаант засаглалын эсрэг чиглэсэн байв. Тэд ганц хүний дур зоргоороо авирласан эрх мэдлийг хязгаарлаж, төрийн эрх мэдлийг хуваарилах уу? Үгүй юу? гэсэн асуудлыг дэвшүүлэн тавьж энэ асуудлаар харилцан адилгүй байр суурьтай байв.

Тухайлбал Английн гүн ухаантан Т.Гоббс /1588-1679/ “ төрийг хүчтэй байлгахын тулд төрийн эрх мэдлийг хуваарилаж болохгүй, энэ нь засаглалын хүчийг сулруулдаг. Цаашлаад хүн бол аугаа их төрийн эрэг шураг, төрийн дээд засаг ард түмний ашиг сонирхлоос үл хамааран оршдог, хуваагдашгүй, хэнд ч шилжүүлж болохгүй зүйл. Хэрвээ төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилвал түүний үндсийг нурааж бие биенээ устгахад хүрнэ” гэжээ.

Харин либерализмын онол болон эрх зүйт төрийг үндэслэгч Английн философич Ж.Локк /1632-1704/ “төрийн эрх мэдлийг хэт төвлөрүүлсэн тохиолдолд ард түмэн боолчлолд орно” гэжээ. Иймээс Ж.Локк төрийн эрх мэдлийг гурван салаа мөчирт хуваарилсан. Үүнд:

1. Хууль тогтоох засаглал /парламент/
2. Гүйцэтгэх засаглал /энд шүүх засаглалыг хамт оруулсан/
3. Холбооны засаглал /гадаад харилцаа/

Эндээс тэргүүлэх үүргийг хууль тогтоох засаглал эдлэх боловч бусад засаглалын нэг адил хуулинд захирагдана. Иргэдийн эрх . эрх чөлөө, өмчид хүндэтгэлтэй хандах ёстой. Хууль тогтоох эрхийг бүх үндэстнийг төлөөлж парламент эдэлнэ.

Парламентаас гаргасан хуулийг хэрэгжүүлэх үүргийг эзэн хаан болон сайд нар хүлээнэ. Хаан гүйцэтгэх болон холбооны засаглалын тэргүүн байна. Дайн болон энхийн асуудал зэрэг олон улсын харилцаатай холбогдсон эрх мэдлийг холбооны засаглал гэнэ. Ж.Локкын үзсэнээр шүүх засаглал нь гүйцэтгэх засаглалын хүрээнд багтана.

Энэ гурван засаглал тус бүрдээ өөрийн харьяа дэд систем, байгуулагуудаас тогтох бөгөөд тэдгээр нь бие даасан шинжтэй байх нь илүү зохимжтой. Хаант засаглалын үед гүйцэтгэх болон холбооны засаглалыг эзэн хаан хариуцна. Эзэн хаан гурван засаглалд бүгдэд нь оролдож тэдгээрийг ерөнхий удирдлагаар хангах үүргийг хүлээнэ.

Эзэн хаан төрийн тэргүүний хувьд хууль тогтоох засаглалын зарим асуудлыг гүйцэтгэх засаглалд шилжүүлж болно.

Ж.Локк засаглалыг хуваахын зэрэгцээ засаглалууд нь тэгш бус эрхтэй , нэг нь нөгөөдөө захирагдсан шатагдсан зэрэг зиндаатай байх бөгөөд хамгийн оройд нь хууль тогтоох засаглал байх ёстой. Иймээс хууль тогтоох засаглалд гүйцэтгэх болон холбооны засаглалууд захирагдана. Гэхдээ захирагдана гэдэг нь идэвхгүй байна гэсэн үг биш, ялангуяа гүйцэтгэх засаглал нь өөрөө идэвхтэй байж парламентад эргэж нөлөөлөх ёстой.

Хэдийгээр хууль тогтоох засаглал нь тэргүүлэх үүргийг хүлээх боловч ард түмэн хууль тогтоох засаглалын үйл ажиллагааг хүлээн авахгүй бол хуулийн үүргийг хүчээр эзэмшин барьж болохгүй, учир нь хууль үнэн бодитой, олон түмний дэмжлэг хүлээсэн, легитим шинжтэй байх ёстой. Түүний энэхүү засаглал хуваах онол нь 18-р зууны үед үүсэн гарсан хөрөнгөтний үндсэн хуульт үзэл санааны эх үндэс нь болсон.

Засаглалыг хувааж байгаа нь түүнийг зүгээр нэг салбарлуулан байршуулж байгаа хэрэг бус, харин засаглалыг хэн нэгэн этгээд булаан авахаас сэрэмжлүүлэх, нэгэнт хуваагдсан засаглалууд хоорондоо уялдаа холбоотой байхыг чухалчилжээ. *Мөн тэрээр засаглал хуваах онолоороо төрийг удирдан жолоодох, засаглалыг хэрэгжүүлэх нь техник зохион байгуулалтын болон нарийн зохицуулсан хөдөлмөрийн хуваарийг шаарддаг төвөгтэй үйл явц болохыг зааж өгчээ.*

Ж.Локк ингэж эрх мэдлийг хуваарилах онолыг анх үндэслэсэн боловч түүний санаанууд ихээхэн зөрчилтэй байсан нь харагдаж байна. /гэхдээ анх үндэслэсэн хүн нь шүү/

Тэрээр шүүх засаглалыг гүйцэтгэх засаглалтай хамтагасан нь алдаа болж энэ нь Ш.Л.Монтескьег хожмоо алдаршуулах шалтгаан болсон юм.

Ж.Локкын дараа Францын соён гэгээрүүлэгч Ж.Руссо /1712-1778/ мөн л төрийн эрх мэдэл хуваарилах онолыг цааш нь үргэлжлүүлэн судалсан.

Ж.Руссо төрийн эрх мэдлийг хуваарилах нь зөв, гэхдээ төрийн эрх мэдлийг хэт олон салаа болгож хуваарилах нь эргээд төрийн бодлогын нэгдмэл байдлыг алдагдуулдаг талтай гэж үзсэн. Тэрээр төрийн эрх мэдлийг :

1. Хууль тогтоох /парламент/

2. Гүйцэтгэх /засгийн газар/ гэсэн харьцаагаар хуваарилах нь хамгийн оновчтой гэж үзжээ. Эндээс парламент тэргүүлэх үүрэгтэй. Хууль тогтоох засаглал нь төрийн зүрх. Парламентийг төлөөлөгчдөөр сонгон бүрдүүлэх бөгөөд ард түмэн зөвшөөрч байж сая хууль эрх зүйн хүчин чадалтай болно гэжээ.

Эндээс үзэхэд Ж.Руссо мөн л зөрчилтэй санааг дэвшүүлж шүүх эрх мэдлийг засаглалын салаа мөчрөөс бүр мөсөн хассан байна.

Ингээд эцэст нь Францын нэрт соён гэгээрүүлэгч, гүн ухаантан Ш.Л.Монтескье /1689-1755/ төрийн эрх мэдэл хуваарилах онолыг шинэ шатанд гаргаж төгс болгож боловсруулсан юм. *Иймээс ч Ш.Монтескьегийн эрх мэдэл хуваарилах онол* гэж түүхэнд алдаршсан юм. Түүнийхээр төрийн эрх мэдлийг :

1. Хууль тогтоох /парламент/

2. Гүйцэтгэх /засгийн газар/

3. Шүүх гэсэн гурван салаа мөчирт хувааж энэ гурван эрх мэдэл нэг гарт төвлөрвөл нийгэм болоод ард түмэн боолчлолд орно гэдгийг анхааруулжээ. *“Тэрбээр үзэхдээ хууль тогтоох эрх мэдэл , гүйцэтгэх эрх мэдэл хоёр нэг гарт байвал тогтоосон хуулийн хэрэгжилт алдарч, нийгэмд дур зоргоороо авирлах явдал газар авах талтайг тэмдэглэсэн байдаг.*

Хууль тогтоох засаглал, шүүх засаглалтай хайт байвал хуулиуд гарсан хойноо шүүх засаглалын үйл ажиллагаанд хутгалдан ороход хүрнэ. Харин гүйцэтгэх засаглал шүүх засаглалд төвлөрч хуулийг сахиулав шүүхийн гарт гүйцэтгэх засаглал орно”¹. /Өнөөгийн монголын засаглалын хямралыг үүнд бүрэн хамааруулж болно. Учир нь 2000 онд үндсэн хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр УИХ-ын гишүүн засгийн газрын гишүүн байж болохыг хуульчилсан./

Ийнхүү ноцтой зөрчил гаргахгүйн тулд эдгээр гурван засаглалыг тус тусад нь хувааж, бие даасан байлгах зорилгоор эрх мэдлийг хуваарилсан.

Гүйцэтгэх засаглал хууль тогтоох засаглалаас ангид хааны мэдэлд байвал зохино.

Хууль тогтоох эрх мэдлийг ард түмнээс сонгогдсон төлөөлөгчид, шүүх эрх мэдлийг ард түмнээс сонгогдсон шүүх хэрэгжүүлнэ гэж үзжээ.

Ш.Л.Монтескье парламентаас батлагдан гарсан хууль олон нийтийн зөвшөөрлийг авах ёстой. Олон нийтийн зөвшөөрлийг аваагүй хуулиуд хууль болж чадахгүй. *Өөрөөр хэлбэл хуулийн эх сурвалж нь ард түмэн. Чухам эндээс үндэслэж парламент нь хоёр танхимтай байх ёстой* гэжээ. Үүнд:

1. Хууль тогтоох танхим /энд угсаа гарвал, өмч хөрөнгө сайтай угсаа залгамжилсан аристократууд орно.

2. Төлөөлөгчдийн танхим /ард түмний төлөөлөгчдөөс бүрдэнэ/

Хууль тогтоох танхим хуулийг тогтоож, төлөөлөгчдийн танхим олон нийтийн зөвшөөрлийг олгох ёстой.

Парламентийн хоёр танхимийн талаарх энэхүү үзэл санааг Ш.Л.Монтескье Английн төрийн тогтолцоог судалсаны үндсэн дээр гаргасан. Ер нь хоёр танхимтай сонгодог парламентийг 10-р зууны

¹ Ш. Монтескье “Хуулийн амин сүнс”

үед Англид үүссэн гэж судлаачид үздэг.

Төрийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван эрх мэдэлд хувааж, тэдгээрийг ард түмнээс сонгогдсон төлөөлөгчид хянаж байх ёстой гэсэн ардчилсан төрийн сонгодог онолыг ийнхүү Ш.Л.Монтескье боловсруулсанаар өөрийгөө дэлхийд алдаршуулжээ.

Ерөөсөө эзэн хааны болоод аливаа төрийн засаглалыг деспот /дарангуйлалын/ хэлбэрт оруулахгүйн тулд л дээрх төрийн эрх мэдлийн ангиллыг соён гэгээрүүлэгчид хийсэн гэж үзэж болно.

Энэ тухай 18-р зууны Францын хөрөнгөтний ардчилсан хувьсгалын нэрт зүтгэлтэн Якобинчуудын гарамгай удирдагч Ж.П.Марат /1743-1793/ “Боолчлолын гинж” гэсэн бүтээлдээ тодорхой тусгажээ. Тэрээр үзэхдээ “*ямар ч төрийн хэлбэр өөрийн хөгжлийн явцад ямагт деспотизм уруу тэмүүлдэг. Энэ нь хүний байгалийн төрөлх шинжтэй холбоотой. Учир нь төрийг хүн удирддаг. Иймээс энэ нь нийгмийн хөгжлийн бодит зүй тогтол. Төрийн засаглал деспотизм уруу тэмүүлж буй тохиолдолд ард түмэн ямар ч эрх чөлөөтэй байсан боолчлолын гинжинд ордог.*

Хүмүүс төрийн засаглалын дарангуйлагч хэлбэрийг хэзээ ч тогтоохыг хүсдэггүй бөгөөд ийм байдлад орохгүйн гол баталгаа нь ард түмэн өөрсдөө” гэсэн дүгнэлтийг хийгээд деспотизм хаанаас гарч ирэх вэ? гэсэн асуултанд хариу өгөхийг хичээжээ. Үүнд:

1. Төрийг удирдаж буй хүмүүс өөрсдийгөө ард түмний эцэг мэтээр төсөөлдөг. Энд ард иргэдэд янз бүрийн хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, найр наадам хийх, том орд харш барих.
2. Хуулийг ард түмний нэрийн өмнөөс гаргахдаа аажим аажмаар өөрийн эрх ашигт нийцүүлэхийг эрмэлздэг. Өөрөөр хэлбэл эцсийн эцэст тухайн хууль эзэн хааныг л хууль болдог.
3. Ард түмэн харанхуй бүдүүлэг, сохор байх нь эзэн хаанд үлэмж ашигтай.
4. Хүмүүс өөрсдийн эрх , эрх чөлөөгөө төдийлөн хамгаалж чаддаггүй. Энэ нь эзэн хаанд мөн л ашигтай.

Ингээд Ж.П.Марат эзэн хааны төрийг деспот хэлбэрт оруулахгүйн гол баталгаа нь эрх мэдлийг хуваарилах явдал гэж үзсэн Ж.Руссо, Ш.Л.Монтескье нарын үзэл санааг тууштай дэмжиж тэмцээр эцэст нь Жирондистуудын илгээсэн алуурчинд алагдсан юм.

Иймээс 1789 онд Францын үндэсний хурал хувьсгалд зоригжсон олон түмний шаардлагаар “Францын хүний болон иргэний эрхийн тунхаг” гэсэн баримт бичгийг баталжээ. Энд хүн төрөхөөсөө эхлээд ямагт эрх чөлөөтэй байсан учир хүн бүхэн тэгш эрхтэй, мөн төрийн эрх мэдлийг салгаагүй улс орон эрх чөлөөгүй, үндсэн хуульгүй гэж зарлажээ.

Монголчууд дэлхийн хүн төрөлхтний түүхэнд төр улсыг удирдах арга ухааныг чадварлагаар хэрэгжүүлж ирсэн баялаг түүхтэй хэдий ч өнөө үед төрөө засаж чадахгүй, хянаж чадахгүй байгаа нь удаа дараагийн засгийн хямралын жишээгээр нотлогдоно. Уг нь түүхээ сөхөж үзвээс 2200 гаруй жилийн тэртээ байгуулагдаж байсан монголын анхны төр улс болох Хүннү гүрэн хоёр танхимтай хурал бүхий төрийн тогтолцоог зохион байгуулж чаджээ.

Энэхүү хоёр танхим нь язгууртны хуралдай, зонхилогчдын зөвлөл гэсэн нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байсан. Язгууртны хуралдайд хааны алтан ургийнхан, язгууртнууд, зонхилогчдын зөвлөлд нь овог аймгийн зонхилогчид, эвэртнүүд, цэргийн жанжид орж байв.



Энэ нь угтаа X зуунд үүссэн Английн сонгодог парламентийн тогтолцоотой ижил төстэй юм.

Яг энэ цаг үетэй зэрэгцээд эртний Грект Афины ардчилал, Ромд Бүгд найрамдах засаглалын хэлбэр үүссэн бөгөөд эдгээр улсуудад мөн л парламентын хоёр танхимийн үндэс суурь тавигджээ.

Тухайлбал, эртний Грект ардын хурал, 500-ын зөвлөл, эртний Ромд ахмадын зөвлөл, сенат гэсэн хоёр танхимтай хурлууд үйл ажиллагаагаа явуулж байсан.

Эртний Грек	Эртний Ром
500 –гийн зөвлөл	Сенат
Ардын хурал	Ахмадын зөвлөл

Өөрөөр хэлбэл МЭӨ 4-3 зууны үед Эртний Грек, Ром, Монгол зэрэг улсуудад 2 танхимтай парламентийн үндэс суурь бие биенээсээ үл хамааран үүсжээ.

Бидний өвөг дээдэс болох Хүннү гүрний төрийн тогтолцооны уламжлалыг Их Нирун улс залгамжилж улмаар Их эзэн богд Чингэс хааны байгуулсан Их Монгол улсын үед улам төгс төгөлдөр боловсронгуй болгож чаджээ.

Тодруулбал, Их Нирун улсын үед язгууртны хуралдай, түшмэдийн эелэлдээн гэсэн хоёр танхимтай хурал ажиллаж байв.



Харин Их Монгол улсын үед хууль тогтоох эрх мэдлийг Их хуралдай болон сэцдийн зөвлөл гэсэн хоёр танхимтай хурал хэрэгжүүлж, гүйцэтгэх эрх мэдлийг Эзэн хаан болон Улсын гоо ван, харин шүүх эрх мэдлийг Чингэс хаанаас бүх насаараа улсын дээд заргач /шүүгч/ байх эрхийг авсан Шихихутаг нар хэрэгжүүлж байлаа.

Энэ нь угтаа Монтескьегийн үндэслэсэн “эрх мэдэл хуваарилах зарчим” мөн бөлгөө.

Чингэс хаан эрх мэдэл хуваарилах зарчмыг бүр 13-р зуунд үндэслэжээ. Шихихутагийг бүх насаар нь Улсын Дээд заргач, Шүүгч болгосон нь шүүх эрх мэдлийг хэнээс ч хараат бус байлгах зорилгоор, /АНУ-д шүүгч нь бүх насаараа шүүгч байх эрхтэй / гүйцэтгэх засаглалыг Мухулай гоо ванд харнуцуулж өөрөө удирдаж байсан нь Гүйцэтгэх эрх мэдлийг хэнээс ч хараат бус байлгах зорилгоор, харин хууль тогтоох эрх мэдлийг Хааны алтан ургаас бүрдсэн Их хуралдайд өгч Их хуралдайгаас гарсан шийдвэрийг 88 гавьяатан сайдаас бүрдсэн сэцдийн зөвлөл / үүнд нэг ч АЛТАН УРГА- ын хүн байгаагүй /авч хэлэлцдэг тогтолцоог бий болгосон.



Энэ үүднээс авч үзвэл Өнөөгийн Америк тэргүүтэй ардчилал өндөр хөгжсөн улс орнуудын төрийн тогтолцооны эх үндэс загварыг Их Монгол улс бүр 13-р зуунд хийж чаджээ. Чингэсийн Их Монгол улс задарч Монголчууд Манжийн эрхшээлд орсон тэр жилүүдэд Монголчуудын бүтээсэн гайхамшигт төрийн тогтолцооны залгамж чанар эвдэгдсэн хэдий ч нэг ч манж, хятад ноён Монголын хошуу, нутаг захирч байгаагүй юм.

Харин 1911 онд Монголчууд дахин сэргэн мандаж Богд хаант Монгол улсыг байгуулахдаа Монгол төрийн тогтолцооны залгамж болсон хоёр танхимтай хурлыг Улсын дээд, доод хурал гэсэн нэртэйгээр бүрдүүлсэн юм.

Энэхүү хоёр танхимтай хурал ч үүргээ сайн биелүүлж тэр үед Чен И-ийн тулган шаардсан Монголыг Дундад иргэн улсын бүрэлдэхүүнд оруулах 64 зүйл гэрээний төслийг Улсын дээд хуралд байсан язгууртан мяндагтнууд хүлээн зөвшөөрч харин доод хуралд байсан ард түмний төлөөлөл болох Хохь тайж доод тушаалын түшмэдүүд хүлээн зөвшөөрөөгүй. Хэрэв энэ үед ард түмний төлөөлөл болсон парламентийн доод танхим байгаагүй бол Монгол хятадад худалдагдах байсан нь түүхэн үнэн.



1921 онд үндэсний ардчилсан хувьсгал ялж, 1924 оны Үндсэн хуулийг батлахдаа Улсын дээд доод хурал гэсэн парламентийн сонгодог загварыг төрийн тогтолцоонд хийж өгсөн боловч 1949 оны Үндсэн хуулинд оруулсан өөрчлөлтөөр хоёр танхимтай парламентийг нэг танхимтай болгон өөрчилж АИХ гэж нэрлэх болжээ. Харин 1990 оны ардчилсан өөрчлөлтийн дараа Улсын бага хурал Ардын их хурал гэсэн хоёр танхимтай парламентийг дахин сэргээсэн боловч 1992 оны шинэ Үндсэн хуулиар Ардын их хурлыг татан буулгаж нэг танхимтай Улсын Их хуралтай болсон. Ингэснээр парламентийн төлөөлөгчдийн танхим гэсэн ард түмний хяналт, хариуцлага тооцох механизм үгүй болж олонхийн эрх мэдлийн давуу байдлыг засаглалын харилцаанд бий болгосон юм.

Эртний монголчуудын төр ёсонд уламжлагдсан дээрх хоёр танхим бүхий хурлыг байнгын ажиллагаатай зэрэгцээ хоёр танхим бүхий сонгодог парламенттай яг адилтгаж болохгүй ч тодорхой түүхэн цаг үеүдэд тус тусын үүргээ амжилттай гүйцэтгэж байсныг монголын түүх гэрчилнэ.

Тиймээс эртний монголчуудын төрт ёсны уламжлалт тогтолцоо нь нэг хүний засаглалыг ардчилалтай хослуулах явдал байв.

Эцэст нь дүгнэхэд монголын улс төрийн систем өнөөдөр хууль ёсны мэт харагдаж байвч легитим чанарын хувьд хямарсан шинжтэй. өргөн олны дэмжлэг, итгэл найдварыг бүрэн хүлээж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, монголын улс төрийн систем хямралт байдалтайгаар оршиж байна.

Зарим судлаачид төрийн засаглалын хэлбэрийг өөрчилж ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс болох, эсвэл хоёр танхим бүхий сонгодог парламентийн засаглалыг сонгох гэх мэтээр цэц булаалдаж буй энэ үед монголын улс төрийн системийг

боловсронгүй болгох чиглэлээр дорвитой судалгаа шинжилгээ хийж, нийгмийг удирдан жолоодох, засаглалын боловсронгуй загварыг уламжлал шинэчлэл, улс төрийн сонгодог онолуудтай нийцүүлж боловсруулах цаг бидэнд иржээ.

НОМ ЗҮЙ

1. История политических и правовых учений. (Учение Ж.Локка о государстве и праве.) / Отв. ред. В.С. Нерсесянца / М., 1996. с.269-283
2. Ш.Л.Монтескье. Хуулийн амин сүнс. УБ., 2008
3. Ж. Руссо. Нийгмийн гэрээний онол. УБ., 2002
4. А.Юндэндорж. Эртний өрнө дорны мэргэдийн улс төрийн сургаалийн түүх УБ., 2002
5. Б.Батчулуун. Эрх чөлөөний дайсан УБ., 2010
6. Д.Лүндээжанцан, Ж.Болдбаатар. Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал УБ., 1997
7. Н.Хавх. Нийгмийн гүн ухаан УБ., 1996
8. Монголын түүх 5-р боть. УБ., 2004
9. Францын хүний болон иргэний эрхийн тунхаг 1789 он